

Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.06.13

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт


Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$31,392.79	\$32,899.70	-4.58%	\$31,730.30	-1.06%	\$34,479.60	-8.95%
S&P 500	\$3,900.86	\$4,108.54	-5.05%	\$3,930.08	-0.74%	\$4,247.44	-8.16%
Nasdaq	\$11,340.02	\$12,012.73	-5.60%	\$11,370.96	-0.27%	\$14,069.42	-19.40%

Европийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 13,761.83	€ 14,460.09	-4.83%	€ 13,739.64	0.16%	€ 15,571.22	-11.62%
FTSE 100	£7,317.52	£7,610.15	-3.85%	£7,277.88	0.54%	£7,088.20	3.24%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,238.99	¥4,089.57	3.65%	¥3,958.74	7.08%	¥5,271.47	-19.59%
Hang Seng	HKD 21,806.18	HKD 21,082.13	3.43%	HKD 19,380.34	12.52%	HKD 28,738.88	-24.12%
Nikkei 225	JPY 27,824.29	JPY 27,761.57	0.23%	JPY 25,740.72	8.09%	JPY 28,958.56	-3.92%

Индексүүдийн өөрчлөлт



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИГЛАХ ШААРДЛАГАТАЙ ТАВАН ЗҮЙЛС

Энэ долоо хоногт хөрөнгийн зах зээл дээр хүлээгдэж буй зүйлс:

1. АНУ-ын бодлогын хүүгийн өсөлт

Өнгөрсөн баасан гарагт АНУ тавдугаар сарын хэрэглээний үнийн индексийн тоон мэдээллийг зарлажээ.

АНУ-ын инфляцийн түвшин гуравдугаар сард оны өмнөөс 8.5 хувиар, дөрөвдүгээр сард 8.3 хувиар өсөөд байсан бол, тавдугаар сарын инфляцийн түвшин 8.6 хувиар өслөө.

Инфляцийн түвшин өсөж, сүүлийн 40 жилийн хамгийн өндөр өсөлттэй гарснаар Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг амлаж байсан 50 нэгжээс өндөр хэмжээгээр өсгөх эрсдэлтэй гэсэн айдас дагуулаад байна.

АНУ-ын бодлогын хүүгийн шийдвэр энэ долоо хоногийн пүрэв гарагт буюу 6 сарын 16 өдөр гарна.

2. Английн бодлогын хүүгийн өсөлт

Англи улс 12-р сараас хойш нийт дөрвөн удаа бодлогын хүүгээ өсгөсөн. Тэгсэн хэдий ч инфляцийн түвшин өндөр хэвээр байгаа ба дөрөвдүгээр сард 9 хувь хүрсэн нь Английн төв банкны санааг зовоож байна.

Английн төв банк жилийн эцэс гэхэд инфляцийг 10 хувь хүрнэ гэсэн таамаглал дэвшүүлсэн. Тиймээс Английн төв банк бодлогын хүүгээ дахин 25 нэгжээр өсгөх хүлээлттэй байна.

Энэ долоо хоногт Англи улс ДНБ, ажилгүйдлийн түвшин зэрэг эдийн засгийн голлох үзүүлэлтийг зарлах болно.

3. Европын инфляцийн түвшин

Европ бүс нутгийн инфляцийн түвшин өсөхөд эрчим хүчний үнийн өсөлт хамгийн ихээр нөлөөлж байна. Дөрөвдүгээр сард инфляци 7.4 хувьтай байсан бол тавдугаар сард 8.1 хувьтай байна хэмээн шинжээчид таамаглаж байна.

Тавдугаар сарын хэрэглээний үнийн индексийг жилийн өмнөхтэй харьцуулсан эцсийн тоо энэ баасан гарагт зарлагдана.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

4. АНУ-ын эдийн засгийн тоон мэдээлэл

Энэ долоо хоногт АНУ-ын жижиглэн худалдаа, аж үйлдвэрийн гарц, үйлдвэрлэлийн үнийн индекс зэрэг эдийн засгийн тоон мэдээллүүд зарлагдах болно.

5. Хөрөнгийн зах зээлийн тогтворгүй байдал

Өнгөрсөн баасан гарагт хэрэглээний үнийн индексийн тоон мэдээлэл зарлагдсаны дараа АНУ-ын голлох индексүүдийн ханш бүгд унасан. S&P 500 2.91 хувиар, Nasdaq 3.52 хувиар, Dow Jones Industrial Average 2.73 хувиар унажээ.

Энэ долоо хоногт зарлагдах эдийн засгийн тоон үзүүлэлт болон бодлогын хүүн өсөлтийн шийдвэр зэрэг томоохон үйл явдлаас хамааран хөрөнгийн зах зээл хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг ажиглах нь зүйтэй.

Европын төв банкны хуралдаан, АНУ-ын инфляци зэргээс үүдэлтэйгээр Европын хөрөнгийн зах зээл уналттай байна

Европын Төв Банкны инфляцийн эсрэг авч буй бодлогын арга хэмжээ мөн АНУ-ын инфляцийн түвшин өндөр гарсан нь Европын хөрөнгийн зах зээлийг уналтад орууллаа. Европын голлох индекс болох Stoxx 600 2.7 хувиар унасан.

Европын төв банк ирэх сард инфляцийг хяналтад оруулах зорилготойгоор бодлогын хүүгээ 25 нэгжээр өсгөх төлөвлөгөөтэй байна. Бүр цаашлаад 9-р сард дахин бодлогын хүүгээ өсгөж магадгүй гэдгээ мэдэгдсэн.

АНУ-ын 5-р сарын хэрэглээний үнийн индекс таамаглаж байснаас илүү өндөр буюу жилийн өмнөхтэй харьцуулснаар 8.6 хувьтай гарсан. Үнийн өсөлтийг хянахын тулд Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүгээ нэмж өсгөх төлөвтэй байна.

Мөн ОХУ болон Украины дайнаас үүдэлтэйгээр дэлхий даяар нийлүүлэлтийн үйл явцад саад учирч байна. Үүнийг дагаад үнийн өсөлтийг өдөөж байгаа нь инфляци өсөж буйн нэг шалтгаан юм.

Эдүгээ өрнөж буй үйл явц нь Европ бүс нутгийн хөрөнгийг зах зээлийг тогтворгүй байдалд оруулж байна.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 06, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
SAIC	NG Energy Partners LP	Academy Sports & Outdoors	WEA	LOVESAC	FIVE BELOW	NIO	DocuSign		
FUTU	coupa	Rockwell Automation	Casey's	Campbell's	ABM	fuelcellenergy	VAIL RESORTS		
跟谁学 GSX Techedu Inc.	GitLab	GIII	smartsheet	THOR	GREIF	bilibili	STITCH FIX		
波奇宠物	HealthEquity	UNFI	GUIDEWIRE	OLLIE'S GOOD STUFF CUPZ	Mission	SIGNET JEWELERS	RENT THE RUNWAY		
SRAX		THE J.M. SMUCKER CO.	VERINT	Kingsoft Cloud	OXFORD	VINCE.	Lakeland		
		華文集團	ReneSola	J.Jill	AMERICAN SOFTWARE		COMTECH		
		chico's FASH	CONCRETE PUMPING HOLDINGS	Vera Bradley	skillsoft		一起		
		HOLOGIC	LIMONEIRA	BROWN-FORMAN	Quantum				
		orion	TORRID SIZES 10 TO 30	AstroNova	ye XT				
		REV Vehicles for life		BAUSCH+LOMB	GRAHAM				
http://eps.sh/cal								© 2022 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 13, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
ORACLE		CORE & MAIN	HIGHTIDE	MAMA MANCINI'S		Kroger	Adobe	Alithya	
intellecheck		Impa	tuya	水滴		Commercial Metals	Beyond Air		
braz		Li-Cycle	IronNet	WILEY		JABIL	PROFRAC		
		FERGUSON	sprinkl						
			ALGOMA						
			planet.						
			ReNew POWER						
			RF INDUSTRIES						
			kaspien						
http://eps.sh/cal								© 2022 Earnings Whispers	

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.